

## МОНГОЛ, ИНДОНЕЗИЙН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн урилгаар Бүгд Найрамдах Индонез Улсын Ерөнхийлөгч Др.Сусило Бамбанг Юдоёно 2012 оны 9 дүгээр сарын 5-наас 7-ны өдрүүдэд Монгол Улсад төрийн айлчлал хийв. Хоёр Ерөнхийлөгч Монгол, Индонезийн харилцаа, хамтын ажиллагааны олон талт асуудлыг ажил хэрэгчээр хэлэлцэж, яриа хэлэлцээ илэн далангүй, элэгсэг дотно уур амьсгалд болов. Ерөнхийлөгч нар мөн бүс нутаг, олон улсын харилцан сонирхсон асуудлаар санал солилцов.

Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг нар Индонез Улсын Ерөнхийлөгч С.Б.Юдоёнод тус тус бараалхав. Бүгд Найрамдах Индонез Улсын Ерөнхийлөгч хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтын хэлхээ холбоог өргөжүүлэх зорилгоор зохион байгуулсан бизнес форумд оролцов.

Хоёр орны төрийн тэргүүн нар бүс нутаг хийгээд олон улсад ардчиллыг түгээн дэлгэрүүлж, бэхжүүлэх нэгдмэл зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө байгаагаа нотлов. Ерөнхийлөгч Юдоёно Монголын иргэний нийгмийн төлөөлөлтэй уулзаж, ардчиллын институцууд, ардчиллын соёл, үнэт зүйлсийг хөхиүлэн дэмжиж буй Индонезийн туршлагаас хуваалцав.

Хоёр Ерөнхийлөгч Монгол Улс, Бүгд Найрамдах Индонез Улсын Харилцаа, Хамтын ажиллагааны Зарчмын тухай 1997 оны Хамтарсан тунхаглалын үзэл санааны дагуу хоёр орны харилцаа, ялангуяа дээд өндөр түвшний улс төрийн яриа хэлцээ, бүс нутаг, олон улсын тавцан дахь хамтын ажиллагааны хүрээнд амжилттай хөгжиж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа тэмдэглэв.

Индонезийн тал ардчилсан нийгэм, чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх, улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад олж буй Монгол Улсын ололт амжилт, мөн саяхан болж өнгөрсөн парламентын сонгуулийг амжилттай зохион байгуулсныг өндрөөр үнэлэв. Түүнчлэн, Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутаг болон олон улсын байгууллагын хүрээнд идэвхтэй гадаад бодлого хэрэгжүүлж, нэр хүнд нь өсөн нэмэгдэж байгааг сайшаав. Монголын тал Индонез Улсыг уламжлалт найрсаг харилцаатай, АСЕАН-ы нөлөө бүхий орон хэмээн үздэг бөгөөд Индонез Улс өөрийн тогтвортой байдал, эдийн засгийн тууштай өсөлт, нийгмийн хөгжилд гарч буй ахиц дэвшил болон бие даасан, идэвхтэй гадаад бодлогоороо Азийн амжилт, ололтын нэгэн жишээ болж буйг өндрөөр үнэлж буйгаа илэрхийлэв.

Хоёр орны хамтын ажиллагааны нөөц боломжийг тодорхойлох, худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх үүднээс богино, дунд хугацааны стратеги хөтөлбөр гаргах нь чухал болохыг Төрийн тэргүүнүүд санал нэгтэй тэмдэглэв. Түүнчлэн 2003 онд байгуулсан хоёр талын хамтын ажиллагааны хамтарсан комиссын механизмыг бүрэн хэмжээнд, үр дүнтэй ашиглах шаардлагатай гэж үзэн энэ зорилгоор Индонезийн тал хоёр талын хамтарсан комиссын анхдугаар хуралдааныг 2013 онд хүлээн авахад бэлэн байгаагаа илэрхийлэв.

Гадаад харилцааны сайд Л.Болд, Гадаад хэргийн сайд Марти Наталегаванарын 2012 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр гарын үсэг зурсан Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНИУ-ын Гадаад хэргийн яам хооронд Дипломат боловсрол, сургалтын чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг Төрийн тэргүүнүүд сайшаан хүлээн авав. Ерөнхийлөгч нар хоёр орны Гадаад хэргийн яам хооронд тогтмол яриа хэлцээ, зөвлөлгөөн хийж байх нь зүйтэй гэж үзэж, улмаар тус тусын нийслэлд Элчин сайдын яамдаа харилцан нээх сонирхлоо илэрхийлэв.

Хоёр орны төрийн тэргүүн батлан хамгаалах салбар дахь хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх, чингэхдээ цэргийн албан хаагчдын харилцан айлчлал, хэлхээ холбоог идэвхжүүлэх, энхийг дэмжих үйл ажиллагааны чиглэлээр болон цэргийн үйлдвэрлэлийн салбарт хамтран ажиллах боломжийг эрэлхийлж ажиллахаар тохиров.

Хоёр орны төрийн тэргүүн терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтын ажиллагаа хөгжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэв.

Хоёр орны төрийн тэргүүн харилцаа, хамтын ажиллагааг харилцан сонирхсон олон чиглэлд өргөжүүлэн хөгжүүлэх боломж байгааг тэмдэглэв. Монгол Улс, Индонез Улс байгалийн нөөц баялаг ихтэй, хөдөө аж ахуйн томоохон үйлдвэрлэл бүхий улс орнууд юм. Талууд яриа хэлэлцээний хүрээнд эдийн засаг, худалдааны харилцааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалт, эрчим хүч, байгалийн баялгийг боловсруулах, мөн хүрээлэн байгаа орчныг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцов.

Талууд эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэл болон аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр санал нэгдэв. Нүүрс олборлох, борлуулах зэрэг чиглэлээр арга туршлагаасаа хуваалцах тухай Индонезийн уул уурхайн үйлдвэрлэгчдийн саналыг монголын тал талархан хүлээж авав.

Бараа, үйлчилгээнийхээ экспортыг нэмэгдүүлэх боломжийг судлах Индонезийн талын сонирхлыг монголын тал дэмжиж буйгаа илэрхийлэв.

Хоёр орны төрийн тэргүүн хүнс, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцов. Тэд хүнсний аюулгүй байдал, тухайлбал хамтарсан судалгаа хөгжлийн ажлыг дэмжих, хөрөнгө оруулалт мөн дэлхийн хүнсний бүтээгдэхүүнийн үнэ, үр тарианы үйлдвэрлэлийн өсөлтийг тогтвортой хадгалах чиглэлээр хамтран ажиллахын чухлыг онцлов.

Хоёр Ерөнхийлөгч иргэд хоорондын харилцаа нь хоёр орны харилцааг өргөжүүлэх гол хөшүүрэг болохын хувьд боловсрол, соёлын салбар дахь хамтын ажиллагааны ач холбогдлыг онцлон тэмдэглэв. Үүнтэй холбогдуулан соёл, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааны баримт бичиг байгуулж ажиллахаар харилцан тохиров. Индонезийн тал техникийн туслалцаа үзүүлэх, монгол иргэдийг сургалтын хөтөлбөрт хамруулах зэргээр Монгол Улсын шилжилтийн үйл явцад хувь нэмрээ оруулж ирсэнд монголын тал талархал

илэрхийлэв.

Ардчиллын үнэт зүйлс, хүний эрхийг дээдэлж, хөхиүлэн дэмжиж буй Азийн улс орнуудыг нэгтгэсэн засгийн газар хоорондын анхны чуулган болох Индонез Улсын санаачилсан Балигийн ардчиллын форумыг Монгол Улс өндрөөр үнэлдгээ илэрхийлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч 2012 оны 11 дүгээр сарын 8-9-ний өдрүүдэд Индонезийн Балид болох Балигийн ардчиллын тавдугаар форумд оролцохыг урьсан БНИУ-ын Ерөнхийлөгчийн урилгыг талархан хүлээн авав.

Индонез Улс Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг 2011-2013 онд амжилттай даргалж байгаа Монгол Улсад баяр хүргээд, ардчиллын боловсрол, бүс нутгийн хамтын ажиллагаа зэрэг АОХН-ийн даргын үйл ажиллагааны тэргүүлэх зорилтыг дэмжиж ажиллахын төлөө байгаагаа илэрхийлэв.

Монгол Улс Кекаматан Хөгжлийн хөтөлбөр, Ардчиллын төлөөх Индонезийн нийгэмлэг зэрэг Индонезийн арга туршлагаас суралцах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч, БНСУ-ын Ерөнхийлөгч нарын 2011 онд санаачилсан Ардчиллын төлөөх Азийн түншлэлд нэгдэх тухай монголын талын урилгыг индонезийн тал нааштай хүлээж авав.

Зүүн өмнөд Ази болон АСЕАН-ы хамтын нийгэмлэгийн хүрээнд цөмийн зэвсгээс ангид бүс байгуулах тухай Индонез Улсын идэвхтэй, манлайлах байр суурийг Монгол Улс сайшаан дэмжив. Индонезийн тал Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсгээс ангид бүс хэмээн зарласны 20 жилийн ойг тохиолдуулан баяр хүргэж, цөмийн зэвсэггүй статусаа баталгаажуулахтай холбоотой эрх зүйн үндсийг баталгаажуулахад чиглэсэн Монгол Улсын бодлогыг дэмжихээ илэрхийлэв.

Индонез Улс 2013 онд АПЕК-ийг тэргүүлэх болсонд Монгол Улс баяр хүргэж, дэмжиж буйгаа илэрхийлэв.

Хоёр орны Ерөнхийлөгч бүс нутагт бүрэлдэж байгаа олон талт хамтын ажиллагааны бүтэц, ялангуяа, Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт зэрэг АСЕАН-ы тэргүүлдэг үйл явцууд мөн АПЕК-ийн талаар харилцан санал солилцов. Монгол Улсын Ерөнхийлөгч дээрх хамтын ажиллагааны бүтцүүдэд Монгол Улс оролцох эрмэлзэлтэй болохыг БНИУ-ын Ерөнхийлөгчид мэдээлэв. Үүнтэй холбогдуулан хоёр орны төрийн тэргүүн бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны бүтцийг бий болгоход Монгол Улс тогтсон журмын хүрээнд оролцоогоо хангах нь чухал болохыг онцлов.

Талууд айлчлалын үеэр доорх баримт бичигт гарын үсэг зурав. Үүнд:

- Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНИУ-ын Гадаад хэргийн яам хооронд Дипломат боловсрол, сургалтын чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг;

- Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам болон Бүгд Найрамдах Индонез Улсын Хөрөнгө оруулалтыг зохицуулах хороо хоорондын Харилцан шууд хөрөнгө оруулалт, бизнесийн түншлэлийг дэмжих хамтын ажиллагааны

тухай харилцан ойлголцлын санамж бичиг;

- Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Үйлдвэр, Хөдөө аж ахуйн яам, БНИУ-ын Хөдөө аж ахуйн яам хоорондын Харилцан ойлголцлын санамж бичиг;

Дээд хэмжээний энэ удаагийн уулзалт хоёр орны уламжлалт, найрсаг харилцааг гүнзгийрүүлж, хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд чухал түлхэц болсон гэдэгт хоёр орны төрийн тэргүүн нар итгэл төгс байгаагаа нотлов.

Индонез Улсын Ерөнхийлөгч Эрхэмсэг ноён Сусило Бамбанг Юдоёоно Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийг хоёр талын тааламжтай үед Индонез Улсад айлчлахыг урив. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж урилгыг талархан хүлээн авав. Талууд айлчлалыг хэрэгжүүлэх цаг хугацааг дипломат шугамаар тохирохоор болов.